



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/174

Арвайхээр

**Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар  
тахлын тархалттай холбогдуулан авах арга  
хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 91 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 20 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалт, эрсдэлийн түвшинтэй холбогдуулан хариу арга хэмжээг авч, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын Улаан түвшинд шилжүүлсүгэй.

2.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал батлагдсан Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Бүрд сумдын төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дараах хязгаарлалтуудыг тогтоосугай.

2.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, түлш шатахуун, газар тариалан, малын өвс тэжээлийн тээврээс бусад аймаг, сумын нутаг дэвсгэрээс гарах болон орох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох,

2.2.Баар, караоке, нийтийн халуун ус, саун бассейн, цахим тоглоом, спорт заал, сүм хийд, сургалтын төвийн үйл ажиллагаа болон олон нийтийг хамарсан бүх төрлийн арга хэмжээ, архи согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглох,

2.3.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал бүртгэгдсэн сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг түр зогсоож, 12 дугаар ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор танхимаар болон цахимаар давтлага зохион байгуулах асуудлыг сумын Онцгой комисс шийдвэрлэх,

2.4.Нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож ажилчдын 5-10 хувийг нь ажлын байран дээр нь ажиллуулах,

011100382

2.5.Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдааны төв, бүх төрлийн дэлгүүр болон үйлчилгээний газрууд (эмийн сан, уст цэг, шатахуун түгээх станцаас бусад)-ын үйл ажиллагааг 09:00 цагаас 17:00 цаг хүртэл, төв бараан захын үйл ажиллагааг 12:00 цагаас 18:00 цаг хүртэл тус тус богиносгосон цагаар ажиллуулах, бусад сумдын хувьд эрсдэлийн түвшин, нөхцөл байдлыг үнэлэн сумын Онцгой комисс шийдвэрлэх,

2.6.Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл сумдын улсын чанартай А0301 автозам дагуу байрлах худалдаа үйлчилгээ болон хоол үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох.

3.Үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр үйлчилгээний газруудад бүртгэл хяналтын системийг тогтмол хөтлүүлж, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, ариутгал халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж, зөрчил гаргасан газруудын үйл ажиллагааг нэн даруй зогсоох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д тус тус даалгасугай.

4.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал бүртгэгдээгүй сумдад нутаг дэвсгэрийн хэмжээндээ Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журмын дагуу холбогдох хязгаарлалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан хэвийн ажиллуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч, сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын цаг үеийн нөхцөл байдлын талаар ард иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлж, хүнсний бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслийн үнийн зохиомол хөөрөгдөлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Д.Цэдэнбалжир)-т тус тус даалгасугай.

6.Бүх төрлийн хүнсний болон бараа бүтээгдэхүүнд зохиомол үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг худалдаа, бизнес эрхлэгчдэд үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн), харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ